



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар A/31

Улаанбаатар хот

Г ШУТИС-ийн харьяа
ШУТИС-Коосэн Технологийн коллежид
суралцагч элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 6.7 дугаар зүйл заалт, БШУ-ны Сайдын 2024 оны “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146 тушаал, “Журам шинэчлэн батлах тухай” А/143 тушаалын нэгдүгээр хавсралт “Оюутан элсүүлэх журам”, ШУТИС-ийн дүрмийн 4.14.10, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн захирлын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/219 дүгээр тушаалаар баталсан “ШУТИС-Коосэн Технологийн коллежийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 3.1 дэх заалт, ШУТИС-Коосэн технологийн коллежийн 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2024-2025 оны хичээлийн жилд “ШУТИС-ийн харьяа ШУТИС-Коосэн Технологийн коллежид суралцагч элсүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. ШУТИС-ийн Элсэлтийн төв комисстой хамтран ажиллаж, элсэлтийн үйл ажиллагааг журамд заасны дагуу зохион байгуулахыг Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч (Ц. Золбадрал)-д үүрэг болгосугай

ЗАХИРАЛ

Д. ДУЛМАА



367740031

ШУТИС-Коосэн технологийн коллежийн
захирлын 2024 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн
13.1 дугаар тушаалын хавсралт



	ШУТИС-Коосэн технологийн коллежид суралцагч элсүүлэх журам ШУТИС-СҮ-ЖУ13	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	2023.05.18 2024.05.02 2
--	--	--	-------------------------------

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

(2024-2025 оны хичээлийн жил)

Боловсруулсан:

ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН СУРГАЛТЫН АЛБА

Хянасан:

ШУТИС-ИЙН СУРГАЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Дэмжсэн:

ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	4
ЗУРГАА. ЭЛСЭГЧИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	4
ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ	5
НАЙМ. ЭЛСЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ.....	6
ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ	7
ХАВСРАЛТ 2. БАЙРШИЛ, ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ.....	8



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- ШУТИС-КООСЭН технологийн коллежид элсэн суралцахаар хүсэлт гаргагчийн элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- Сургуулийн материаллаг бааз, анги кабинетийн хүрэлцээ зэргээс хамааран шинээр элсэх суралцагчдын тоог тогтооно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- Энэхүү журам нь ШУТИС-КООСЭН технологийн коллежид 2024-2025 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх үйл явцыг хамарна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- Дээд боловсролын тухай хууль;
- Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ны 115 дугаар “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах” тухай тогтоол;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн A/66 дугаар тушаалаар батлагдсан “Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн A/143 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Оюутан элсүүлэх журам”, хоёрдугаар хавсралт “Элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал”;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн A/146 дугаар “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” тушаал;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 05-р сарын 31-ны өдрийн A/241 дугаар Мэдээллийн технологийн хөтөлбөрийн тушаал;

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- Элсэлтийн шалгалт** гэж элсэх хүсэлтэй суралцагчдын суурь боловсролын мэдлэг, чадварын түвшинг тогтоох зорилго бүхий шалгалтыг;
- Элсэхийг хүсэгч** гэж технологийн коллежид элсэх хүсэлт гаргаж бүртгүүлсэн иргэнийг;
- Элсэгч** гэж хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан иргэнийг;
- Элсэлтийн систем** гэж элсэлтийн цахим бүртгэлийн системийг;
- Элсэлтийн комисс** гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- Элсэлтийн бүртгэл** гэж элсэлтийн веб хуудсанд нэвтэрч бүртгэл хийлгэх үйл ажиллагааг;
- Элсэлт баталгаажуулалт** гэж шалгалтад тэнцэн онооны жагсаалтын дагуу хяналтын тоонд багтсан суралцагч сургалтын төлбөрөө төлж элсэлтээ баталгаажуулах үйл явцыг;
- Элсэлтийн шалгалтын хураамж** гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад зарцуулах мөнгөн хөрөнгийг;
- Хяналтын тоо** гэж тухайн жилд элсүүлэх суралцагчийн тоог;



ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. **ШУТИС-Коосэн технологийн коллежийн захирал**
 - 5.1.1. Элсэлтийн комиссыг байгуулж удирдлагаар хангаж ажиллана.
 - 5.1.2. Элсэлтийн комиссын ажлын төлөвлөгөө, төсвийг батална.
 - 5.1.3. Элсэлтийн үйл ажиллагаа, түүний үр дүнгийн тайлантай танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.
 - 5.1.4. Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
- 5.2. **Элсэлтийн комисс**
 - 5.2.1. Элсэлтийн комисс нь захирал, сургалтын албаны дарга, ажилтан, тэнхимиин эрхлэгч, захирлын туслах, шалгалтын материал засч, дүнг нэгтгэх багш болон бусад нэгжийн бүрэлдэхүүнтэй байна.
 - 5.2.2. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, удирдамж, төсвийг элсэлтийн комиссын нарийн бичгийн дарга захирлаар батлуулж, гишүүд хэрэгжүүлнэ.
 - 5.2.3. Элсэлтийн маркетингийн үйл ажиллагаа зохион байгуулна.
 - 5.2.4. Элсэлтийн үеийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.
 - 5.2.5. Байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд аливаа байдлаар сөргөөр нөлөөлөх ташаа мэдээлэл, сурталчилгаа явуулахгүй байх, ёс зүйг эрхэмлэх;
 - 5.2.6. Сургуулийн дүрэм, журам зөрчсөн ямар нэгэн дутагдал гаргаж буй элсэгчдэд зохих ёсны шаардлага тавих;

ЗУРГАА. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 6.1. Элсэлтийн комисс батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн хүрээнд элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.
- 6.2. Элсэлтийн комисс нь элсэхийг хүсэгчдэд зориулсан дараах мэдээллийг сургуулийн вэб хуудас болон цахим сувгуудаар мэдээллэнэ. Үүнд:
 - 6.2.1 Элсэгчдэд тавигдах шаардлага;
 - 6.2.2 Элсэлтийн бүртгэл болон шалгалт зохион байгуулах хугацаа, байршил
 - 6.2.3 Сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээлэл;
 - 6.2.4 Элсэлтийн шалгалттай холбоотой шаардлагатай мэдээлэл
 - 6.2.5 Сургалтын төлбөрийн мэдээлэл
 - 6.2.6 Элсэлтийн шалгалтын хураамжийн мэдээлэл
- 6.3. Элсэхийг хүсэгчдэд тавих ерөнхий шаардлага
 - 6.3.1 Суурь боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээ 70% ба түүнээс дээш
 - 6.3.2 Сонгосон хөтөлбөрөөрөө суралцах сонирхолтой байх
- 6.4. Элсэлтийн бүртгэл
 - 6.4.1 Элсэхийг хүсэгчид 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2024 оны 6-р сарын 12-ны өдрийн 12:00 цаг хүртэл <https://elselt.edu.mn/> хаягтай вэб сайтаар дамжуулан улс орон даяар цахим хэлбэрээр бүртгүүлнэ.
 - 6.4.2 Элсэлтийн шалгалтын хураамж 20000 (хорин мянга) төгрөг байна. Бүртгэлийн хураамж төлөх дансны мэдээлэл: Хаан банк: ШУТИС-Коосэн технологийн коллеж, 5031748624
 - 6.4.3 Бүртгэлийн хураамжийг элсэлтийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулах тул буцаан олгохгүй
 - 6.4.4 Элсэгч нь вэб хуудсанд шаардлагатай мэдээллийг оруулж бүртгэлийг



баталгаажуулах ба шалгалтад ирэхдээ бүртгэлийн хуудсаа хэвлэж, төрсний гэрчилгээний хамт авч ирнэ.

ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 7.1 Шалгалтын үндсэн зарчим
 - 7.1.1 Шалгалтын даалгавар, шалгуур түвшинд нь тохирсон, үнэн зөв, суралцагчдад ойлгомжтой, бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх болон тэдний сэтгэн бodoх чадварыг нээн илрүүлэх боломжтой байх;
 - 7.1.2 Шалгалт шударга, ил тод байх;
- 7.2 Элсэлтийн шалгалтыг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 10.00 цагт ШУТИС-ийн хичээлийн II байранд дараах үе шаттайгаар зохион байгуулагдана. Үүнд:
 - Бичгийн шалгалт: Математикийн хичээлийн агуулга 70%, физикийн хичээлийн агуулга 30%-ийн бүтэцтэй байна.
 - Ярилцлагын шалгалт: Элсэлтийн шалгалтад 70%-иас дээш дүгнэгдсэн тохиолдолд эхний шатанд тэнцсэнд тооцон, ярилцлагын шалгалтад оруулна. Ярилцлагын товыг сургуулийн веб сайт болон мэдээллийн самбарт зарлана.
 - Бичгийн шалгалтын үргэлжлэх хугацаа 100 минут, ярилцлагын шалгалтын хугацаа шалгуулагч тус бүрд 10-15 минут байна.
- 7.3 Шалгалтын сэдэв боловсруулах багийг томилох, нууцлалыг хадгалан ажиллах үүргийг элсэлтийн шалгалтын комисс хариуцна.
- 7.4 Шалгалтын сэдвийг тухайн хичээлүүдийн суурь боловсролын агуулгын хүрээнд боловсруулна.
- 7.5 Элсэлтийн комисс шалгалтын сэдвийг шалгалт эхлэхээс нэг цагийн өмнө шалгуулагчдын тоогоор хувилж бэлтгэнэ.
- 7.6 Элсэлтийн шалгалтын үйл явцын дэгийг элсэлтийн комиссын дарга батална.
- 7.7 Шалгалт эхлэхээс хагас цагийн өмнө комиссын гишүүд шалгуулагчдыг бүртгэлийн хуудастай тулган хуваарьт ангид оруулж хянагч багш нарыг томилно.
 - 7.7.1 Хянагч багш шалгалтын дэгийг уншиж танилцуулна.
 - 7.7.2 Хянагч багш шалгалтын материалыг тарааж, шалгалтыг эхлүүлнэ.
 - 7.7.3 Шалгалтын хугацаа дуусмагц хянагч багш шалгуулагчдын материалыг шифрлэж, хурааж авна.
 - 7.7.4 Хянагч багш шалгалтын явцын талаар тэмдэглэл хөтөлнө.
 - 7.7.5 Шалгалтын явцад шалгуулагч нь дэг зөрчвэл шалгалтаас шууд чөлөөлнө.
- 7.8 Шалгалтын материалыг томилогдсон багш засаж, шалгалтын хуудас болон оноог комисст хүлээлгэн өгнө.
- 7.9 Элсэлтийн комисс шалгалт зохион байгуулагдсан өдөр шалгалтын оноог сургуулийн вэбсайт, facebook хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.
- 7.10 Элсэхийг хүсэгч нь шалгалтын оноо, үр дүнтэй холбоотой өөрийн материалыг шалгах хүсэлт гаргаж болно.
- 7.11 Нэмэлт элсэлт авах
 - 7.11.1 ШУТИС-Коосэн технологийн коллеж нь ШУТИС-ийн элсэлтийн төв комиссын шийдвэрийг үндэслэн нэмэлт элсэлтийн үйл ажиллагааг хичээлийн жилийн намрын улиралд зохион байгуулж болно.
 - 7.11.2 Элсэлтийн комисс нэмэлт элсэлтийн үйл ажиллагааг энэхүү журамд зааснаар зохион байгуулна.



7.11.3 Хичээлийн жилийн хавар, намрын улиралд анги дүүргэлтийг нөхж, энэхүү журамд заасан шаардлагыг хангасан суралцагчийг шилжүүлэн суралцуулж болно.

НАЙМ. ЭЛСЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ, ЭЛСҮҮЛЭХ

- 8.1 Элсэлтийн шалгалтын оноогоор жагсаан хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг элсүүлнэ.
- 8.2 Төрөлжсөн болон олон улсын олимпиадад эхний 5 байр эзэлсэн бол амжилтыг харгалзан шалгалтгүйгээр шууд элсүүлж, баталгаажуулалтын хуудас олгоно.
- 8.3 ШУТИС-Коосэн Технологийн коллежаас улс орон даяар Ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн суралцагчдын дунд зохион байгуулдаг “Инженер сурагч” бүтээлийн уралдаанд эхний 3 байр эзэлсэн суралцагчийг элсэлтийн шалгалтгүйгээр элсүүлж, баталгаажуулалтын хуудас олгоно.
- 8.4 Элсэлтийн комиссын шийдвэрээр шалгалтад тэнцсэн элсэгчдийг 2024 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 31-ны хооронд ШУТИС-ийн VIII байрны 302 тоотод бүртгэнэ. Элсэгч нь бүртгүүлэхээр ирэхдээ доорх материалыг бүрдүүлэн, асран хамгаалагчийн хамт ирнэ. Үүнд:
 - Сурагчийн хувийн хэрэг (шилжүүлэг хийлгэсэн байх)
 - Суурь боловсролын гэрчилгээ
 - Төрсний гэрчилгээний баталгаажуулсан хуулбар
 - Эцэг эх, асран хамгаалагчийн иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
 - 2 хувь цээж зураг /сүүлийн 6 сарын/
 - Сургалтын төлбөр төлсөн баримт
- 8.4 Суралцагчийн материалыар хувийн хэрэг бүрдүүлж төгсөх үед хүлээлгэж өгнө. Зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэж, шаардлага хангасан оюутныг нөхөн элсүүлнэ.
- 8.5 Элсэлтийн үйл ажиллагаанд холбогдох аливаа маргаан, зөрчлийг бичгээр элсэлтийн комисс хүлээн авч, шийдвэрлэнэ.



ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: [R]-Хариуцан хийж, гүйцэтгэх; [A] -Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; [C]-Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; [I] – Алхмын гаралтын мэдээлэл авах

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)				
				Э	КТКЗ	ЭТК	МТТ	КТК
1	Элсэлтийн журам		ШУТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан журам		A			
2	ШУТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан журам	<pre> graph TD Start(()) --> Step1[1. Элсэлтийн комисс байгуулах] Step1 --> Step2[2. Элсэлтийн бүртгэл ажлыг болжгэх] Step2 --> Step3[3. Элсэлтийн хүсэгчдийг бүртгэх] Step3 --> Step4[4. Шалгарт авах ажлыг зохион байгуулах] Step4 --> Step5[5. Онооны зэмбэлэлт хийх] Step5 --> Step6[6. Онооны жагсаалт хийх] Step6 --> Step7[7. Хөтөлбөрийн сонгопт хийж баталгаажуулах] Step7 --> Step8[8. Суралцагчийн код] Step8 --> Step9[9. Сургалтын гэрээ] Step9 --> End(()) </pre>	Элсэгчдэд зориулсан гарын авлага, Элсэлтийн маркетинг, сурталчилгаа, Элсэлтийн вэб хуудас, Онлайн төлбөр, тооцоо	I	C	R	C	C
3	Элсэгчдэд тавигдах шаардлага		Бүртгэлийн хураамж, Элсэхийг хүсэгчдийн бүртгэл	C	I	R	C	C
4	Элсэхийг хүсэгчдийн бүртгэл		Шалгалтын дүн	C	I	R		C
5	Шалгалтын дүн		Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт		C	R		
6	Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт		Элсэлтийн вэб хуудас дахь мэдээлэл	I	C	R		I
7	Элсэлтийн вэбийн бүртгэл		Шинэ оюутны бүртгэл, Цахим суралцах эрхийн бичиг	C		R	C	C
8	Суралцагчийн код			C	A	C	C	
9	Сургалтын гэрээ		Оюутны цахим анкет, Сургалтын гэрээ, Оюутны үнэмлэх	R	A	C		A

Э – Элсэгч, КТКЗ – Коосэн ТК-ийн захирал, ЭТК - Элсэлтийн төв комисс, МТТ – Мэдээлэл технологийн төв, КТК – Коосэн ТК

ШУТИС-Коосэн технологийн коллежийн
захирлын 20 2014 оны 07 дугаар сарын 30 -ны өдрийн
Ажлын дугаар тушаалтын хавсралт



ХАВСРАЛТ 2. БАЙРШИЛ, ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар холбогдох авна.

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
8-р хороо, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг Улаанбаатар, ШУТИС VIII-байр
Монгол улс 14191

Утас: (976)-77110096

Утас: (976)-77110097

Вэб хуудас: <http://www.kosentc.edu.mn/mn/>

Мэйл хаяг: must-kosen@must.edu.mn